

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн  
2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/12-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Сүхбаатар сум  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитор: Т.Одсүрэн

Утас: 70362442 Цахим хаяг: [odsurent@audit.gov.mn](mailto:odsurent@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт .....	14
3.5.1 Мөнгөн хөрөнгө .....	14
<b>3.5.2 Авлага</b> .....	14
3.5.3 Бараа материал .....	16
3.5.4 Үндсэн хөрөнгө .....	17
3.5.5 Өр төлбөр .....	18
3.5.6 Засгийн газрын хувь оролцоо .....	19
3.5.7 Орлогын данс .....	20
3.5.8 Зардлын данс.....	20
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	23
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	26
3.8 Аудитын гол асуудал .....	27
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..	27
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	27
3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт .....	28
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	28
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	29
4.2 Албан шаардлага.....	30
4.3 Зөвлөмж .....	32
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	34

### Товчилсон үгийн жагсаалт

<b>ААТҮГ</b>	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>АНУ</b>	Америкийн нэгдсэн улс
<b>БСШУЯ</b>	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
<b>ЗДНХ</b>	Засаг даргын нөөц хөрөнгө
<b>ЗДТГ</b>	Засаг даргын Тамгын газар
<b>ИТХ</b>	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
<b>МУЕА</b>	Монгол Улсын Ерөнхий аудитор
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>ОНӨГ</b>	Орон нутгийн өмчийн газар
<b>ОНХС</b>	Орон нутгийн хөгжлийн сан
<b>СТСХ</b>	Санхүү төрийн сангийн хэлтэс
<b>СХС</b>	Сум хөгжүүлэх сан
<b>ТБОНӨХБАУХА</b>	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах
<b>ТЕЗ</b>	Төсвийн ерөнхийлөн захирагч
<b>ТЗШ</b>	Тусгай зориулалтын шилжүүлэг
<b>ТӨБЗГ</b>	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
<b>ТТЗ</b>	Төсвийн төвлөрүүлэн захирагч
<b>УИХ</b>	Улсын Их Хурал
<b>УСНББОУС</b>	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
<b>ХАА</b>	Хөдөө аж ахуй
<b>ХХОАТ</b>	Хувь хүний орлогын албан татвар
<b>ХЧТА</b>	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж
<b>ЭМДЕГ</b>	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
<b>ЭМДС</b>	Эрүүл мэндийн даатгалын сан
<b>ЭМТ</b>	Эрүүл мэндийн төв
<b>ЭСЯ</b>	Элчин сайдын яам



СҮХБААТАР СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Т.ГАНТУЛГА ТАНАА

## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.25 № СЭА-2022/12-НА-СТА-ТТЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад сумын ЗДТГ, багуудад багаж, техник хэрэгсэл, тавилга худалдан авах болон урсгал засварын зардлыг нийт 31,152.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн тодотгол хийсэн,
2. Холбогдох мэргэжлийн байгууллагын акт, дүгнэлт, ТӨБЗГ, аймгийн ОНӨГ-ын шийдвэр болон бусад шаардлагатай баримт материалын үндэслэлгүйгээр 10,451.3 мянган төгрөгийн өртөг бүхий чулуун склад, 28,420.0 мянган төгрөгийн авто машин / тоёота марк-2, прадо-95, ачааны самосмал / зэрэг нийт 38,871.3 мянган төгрөгийн үл хөдлөх хөрөнгө болон тээврийн хэрэгслийг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 40 дүгээр тогтоолоор акталж, данс бүртгэлээс хасах шийдвэр гаргаж, хэрэгжүүлсэн.

3. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс дараах байгууллага, хөтөлбөрүүдэд авлага, өр төлбөр үүсгэсэн болон батлагдсан төсөв хэтрүүлсэн. Үүнд:

- СХС-аас олгох зээлийг төлөвлөснөөс 1,100.0 мянган төгрөгөөр санхүүжүүлж, батлагдсан төсвийг хэтрүүлсэн,
- ИТХ нь цалин илүү олгож 311.4 мянган төгрөгийн авлага үүсгэсэн,
- ЗДТГ нь НДШ-д 209.5 мянган төгрөгийг илүү шилжүүлж, авлага үүсгэсэн,
- Бэлчир бүсийн Ойн анги нь үнэт цаасны төлбөрт 40.2 мянган төгрөгийг илүү шилжүүлж, авлага үүсгэсэн,
- “Эмнэх баг” өрхийн эрүүл мэндийн төв нь цалингийн 688.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн.
- 1-р цэцэрлэг гэрэл цахилгаан, цэвэр бохир усны 1,177.1 мянган төгрөг, 4-р сургууль ХХОАТ, НДШ-ийн 1,276.4 мянган төгрөгийн өр төлбөр, спорт сургууль ХХОАТ-ын 1,284.4 мянган төгрөгийн авлага үүсгэсэн .

4. Дараах байгууллагууд анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан. Үүнд:

- ЗДТГ нь зардлын төсөв, тооцоо, судалгааг урьдчилан тооцоогүй, гүйцэтгэлийн баримтууд бүрдүүлээгүй болон жолоочийн тооцооны хуудсыг холбогдох маягт аргачлалаар хөтлөөгүй, шатахууны норм нормативын тооцоололгүй зэргээр ЗДНХ-өөс / 2021 оны А/31, А/54, А/96, А/185, А/194, А/287 дугаар захирамжаар / Ковид-19-ийн гэрийн эргэлтийн багийг дэмжих, хавьтлаас шинжилгээ авах, вакцинжуулалт хийх, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зэрэг арга хэмжээнүүдийн нийт **93,846.2** мянган төгрөгийн зарлагын гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан,
- ИТХ нь 2021 оны үйл ажиллагааны тайлан мэдээлэл бүхий 1000 ширхэг сэтгүүл, гарын авлага, тогтоол шийдвэрийн эмхэтгэл хийлгэхэд 3,050.0 мянган төгрөг, сумын хамтарсан багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж зөвлөн туслах үйлчилгээнд 1,800.0 мянган төгрөг, жолоочийн тооцооны хуудсыг холбогдох маягт, аргачлалаар хөтлөөгүй, шатахууны норм, нормативыг зөрүүтэй тооцсон 6,046.2 мянган төгрөг зэрэг нийт **10,896.2** мянган төгрөгийн зарлагын ажил гүйлгээг гүйцэтгэж, шууд зардлаар тайлагнасан.

5. Цалин хөлсний тооцооллыг буруу хийснээс цалин, урамшууллыг илүү болон давхардуулан олгосон. Үүнд:

- 1-р цэцэрлэг: Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа багш Ё.Нарантуяад гэрээнд заагаагүй 1,150.3 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс бодож олгосон,
- 1-р сургууль: Улирлын амралттай хугацаанд бус 8 дугаар сард багш нарт анги даалтын нэмэгдэлд 1,862.8 мянган төгрөгийг бодож олгосон.
- 3-р сургууль: ХЧТА тэтгэмжийг цалинтай давхардуулан болон төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, хавсран ажилласны нэмэгдэлд нийт 928.7 мянган төгрөг илүү тооцож олгосон.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 34 дугаар зүйлийн 34.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2 дугаар зүйл, Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2009 оны 30 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Сумын төсвийн байгууллагын үндсэн хөрөнгө, тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжөөс бусад эд хөрөнгийг эзэмших, ашиглах актлах журам”-ын 2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,728,201.70</b>	<b>3,030,328.10</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>485,425.40</b>	<b>607,761.50</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>1,078,395.40</b>	<b>1,039,260.60</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>1,164,380.90</b>	<b>1,383,306.00</b>
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>22,292,037.90</b>	<b>25,892,605.00</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>22,292,037.90</b>	<b>25,892,605.00</b>
<b>39200</b>	Биет хөрөнгө	20,492,755.80	24,037,241.20
<b>39300</b>	Биет бус хөрөнгө	<b>1,799,282.10</b>	<b>1,855,363.80</b>
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>25,020,239.60</b>	<b>28,922,933.10</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>40,164.10</b>	<b>108,631.20</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>40,164.10</b>	<b>108,631.20</b>
<b>41300</b>	Өглөг	40,164.10	108,631.20
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>24,980,075.60</b>	<b>28,814,301.90</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>24,980,075.60</b>	<b>28,814,301.90</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,106,760.40	9,106,760.40
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>6,773,300.40</b>	<b>10,612,297.40</b>
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,100,014.80	9,095,244.10
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>25,020,239.60</b>	<b>28,922,933.10</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>18,098,181.20</b>	<b>19,490,951.90</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>1,073,961.00</b>	<b>1,074,907.80</b>
110	Орлогын албан татвар	932,100.00	866,396.90
1100	Хувь хүний орлогын албан татвар	932,100.00	866,396.90
113	Хөрөнгийн албан татвар	4,998.00	20,273.40
118	Бусад татвар, төлбөр, хураамж	136,863.00	188,237.50
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,382,668.40</b>	<b>5,062,483.40</b>
120	Нийтлэг татварын бус орлого	1,382,668.40	5,062,483.40
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>15,641,551.70</b>	<b>13,353,560.80</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>17,592,061.40</b>	<b>15,409,194.20</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>17,592,061.40</b>	<b>15,409,194.20</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>14,185,247.80</b>	<b>14,998,079.40</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,454,185.90	8,621,757.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,068,365.80	1,128,144.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,287,513.00	1,367,905.20
2104	Хангамж, бараа материалын зардал	226,942.70	263,838.70
2105	Нормативт зардал	238,718.60	213,752.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	97,224.00	131,649.60
2107	Томилолт, зочны зардал	7,235.40	4,961.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	620,824.80	744,432.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,184,237.70	2,521,636.80
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,406,813.60</b>	<b>411,114.80</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>506,119.80</b>	<b>4,081,757.70</b>

**Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	897.60	891.60
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	239,555.70	248,423.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	267,461.70	3,834,226.40

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>30,807,768.90</b>	<b>30,807,768.90</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(5,845,332.60)	(5,845,332.60)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	24,962,436.30	24,962,436.30
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(249,822.50)	(249,822.50)
9	<b>Тайлант үеийн үр дүн</b>	<b>267,461.70</b>	<b>267,461.70</b>
10	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>24,980,075.60</b>	<b>24,980,075.60</b>
11	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>24,980,075.60</b>	<b>24,980,075.60</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,770.70	4,770.70
13	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>24,984,846.20</b>	<b>24,984,846.20</b>
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(4,770.70)	(4,770.70)
19	Тайлант үеийн үр дүн	3,834,226.40	3,834,226.40
20	<b>2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>28,814,301.90</b>	<b>28,814,301.90</b>

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>17,154,598.20</b>	<b>14,871,095.10</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>1,073,961.00</b>	<b>1,074,907.80</b>
110	Орлогын албан татвар	932,100.00	866,396.90
1100	Хувь хүний орлогын албан татвар	932,100.00	866,396.90
113	Хөрөнгийн албан татвар	4,998.00	20,273.40
118	Бусад татвар, төлбөр, хураамж	136,863.00	188,237.50
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	126,627.50	160,045.00
1181	Газрын төлбөр	9,960.10	27,551.50
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	275.40	641.00
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>364,810.10</b>	<b>539,589.90</b>
120	Нийтлэг татварын бус орлого	364,810.10	539,589.90
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>15,715,827.10</b>	<b>13,256,597.40</b>
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>16,346,732.00</b>	<b>14,051,521.70</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>16,346,732.00</b>	<b>14,051,521.70</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>12,865,865.20</b>	<b>13,622,070.00</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,448,719.70	8,622,676.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,068,904.10	1,124,043.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,288,075.50	1,367,333.80
2104	Хангамж, бараа материалын зардал	145,368.50	159,407.90
2105	Нормативт зардал	312,704.80	322,514.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	129,275.40	174,406.10
2107	Томилолт, зочны зардал	7,235.40	4,916.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	717,040.10	735,507.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	748,541.70	1,111,264.40

**Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,480,866.90	429,451.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	807,866.20	819,573.40
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	484,420.30	595,237.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	484,420.30	595,237.30
2200	Дотоод эх үүсвэрээр	484,420.30	595,237.30
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(484,420.30)	(595,237.30)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(185,000.00)	(102,000.00)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	185,000.00	102,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	138,445.90	122,336.10
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	346,979.50	485,425.40
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	485,425.40	607,761.50

**2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,683,431.60	13,939,221.24	744,210.36	94.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,095,270.00	13,604,230.43	491,039.57	96.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,914,477.10	13,432,396.56	482,080.54	96.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,708,292.60	8,613,807.21	94,485.39	98.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,158,962.30	1,123,048.84	35,913.46	96.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,608,377.60	1,367,333.76	241,043.84	85.0
2104	Хангамж, бараа материалын зардал	153,798.40	148,821.63	4,976.77	96.8
2105	Нормативт зардал	335,650.60	236,508.28	99,142.32	70.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	456,109.50	455,760.67	348.83	99.9
2107	Томилолт, зочны зардал	5,751.90	4,916.20	835.70	85.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	643,231.90	639,366.12	3,865.78	99.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	844,302.30	842,833.85	1,468.45	99.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	180,792.90	171,833.88	8,959.02	95.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	180,792.90	171,833.88	8,959.02	95.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	388,161.60	232,990.80	155,170.80	60.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	200,000.00	102,000.00	98,000.00	51.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,683,431.60	14,083,785.36	599,646.24	95.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,855,521.90	10,616,531.57	238,990.33	97.8
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,511,142.20	3,235,302.58	275,839.62	92.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	316,767.50	231,951.22	84,816.28	73.2

**Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	163,388.51	(163,388.51)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	309,052.64	(309,052.64)	-
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>8,307.00</b>	<b>8,016.00</b>	<b>8,016.00</b>	<b>96.5</b>
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	22.00	18.00	18.00	81.8
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	758.00	757.50	757.50	99.9
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	6,769.00	6,483.00	6,483.00	95.8
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	5,160.00	5,157.00	5,157.00	99.9
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	1,609.00	1,326.00	1,326.00	82.4
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	758.00	757.50	757.50	99.9

**2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Код	Үзүүлэлт	
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>569,546.37</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>542,271.27</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>524,084.76</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,869.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	994.73
2104	Хангамж, бараа материалын зардал	13,065.70
2105	Нормативт зардал	89,246.17
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,417.18
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	98,861.39
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	297,630.31
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,186.51</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,023.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,163.51
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>27,275.10</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	27,275.10
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>569,546.37</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	569,546.37
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>-</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын төсвийн төвлөрүүлэн захирагч *Ицаашид Сүхбаатар сумын ТТЗ гэх*-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж бүртгэл тайланд тусгаж байх, үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох ашиглалтын жилийг үнэн зөв тогтоох, төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэсний үндсэн дээр, сар бүр ур чадварын нэмэгдэл олгож байх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Одсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1/31 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хууль тогтоомж төр засгийн бусад шийдвэрийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн оновчтой бодлого зохицуулалтаар ханган төрийн албаны стандартыг бүрэн хэрэгжүүлэх” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Эдийн засгийн бодлого: Хүн амын орон сууц, эрчим хүч, усан хангамж, ариутгах талаар баримтлах, бодлогын хэрэгжилтийг хангаж иргэдийн эрүүл орчинд ая тухтай амьдрах нөхцөлийг тогтвортой сайжруулна.
- Төсвийн зардлыг хэмнэлттэй зарцуулах, шилэн дансны ил тод байдлыг хангаж суманд ирж буй төсөл хөтөлбөрүүдийг нээлттэй болгож иргэдийн үнэт цаасны зах зээлийн мэдлэгийг дээшлүүлнэ.

- Худалдааны байгууллагаас ард иргэдийг эрүүл хүнсээр хангах, иргэдэд соёлч боловсон үйлчилж байгаа эсэхэд хяналт тавьж, ахуйн үйлчилгээг нэмэгдүүлэх бодлого барьж ажиллана.
- Эрүүл мэндийн бодлого: Эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг чадавхжуулж, иргэн бүрийг урьдчилан сэргийлэх үздэг тандалтад хамруулж халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулан Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ.
- Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн өрх, иргэдэд үзүүлэх халамж, эрүүл мэндийн олон талт үйлчилгээг зохион байгуулах,
- Хөдөө аж ахуйн бодлого: Мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг ханган нийт малд эзлэх эрлийз, цэвэр эрлийз малын тоо толгойг нэмэгдүүлж эрүүл аюулгүй хүнсний хангамжийг сайжруулна.
- Газар тариалангийн үйлдвэрлэлд төрөөс баримталж байгаа бодлого шийдвэрийг хэрэгжүүлж, хүлэмжийн болон зоорины аж ахуй эрхлэлтийг дэмжинэ.
- Засаглалын бодлого: Төрийн үйлчилгээнд ухаалаг тогтвортой засаглалыг бэхжүүлж, чадахуйн зарчимд суурилсан хариуцлагатай, шуурхай, нээлттэй, ил тод төрийн үйлчилгээг хүргэнэ.
- Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хуулийн хэрэгжилтийг чанд мөрдүүлэх замаар гэмт хэргийн гаралтыг бууруулан иргэдийн аюулгүй амьдрах орчин нөхцөлийг сайжруулна.
- Хүний хөгжлийн бодлого: Боловсролын салбарт ажиллагсдыг чадавхжуулж, сурч боловсрох, хөгжих, ажиллах, эрүүл аюулгүй ээлтэй орчныг бүрдүүлж боловсролын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэж, хөгжлийг түүчээлэх чадвартай монгол хүнийг хөгжүүлнэ.
- Хүнс, худалдаа, ХАА, байгаль орчны бодлого: Эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлж эрүүл аюулгүй хүнсний хангамжийг сайжруулна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2020-2024, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, үр дүнг тооцож, иргэд олон нийтэд мэдээлэх,
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, Засгийн газрын тогтоол, албан даалгавар, ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах, тайлагнаж ажиллах,
- Аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих,
- Аймгийн “Чанарыг эрхэмлэх жил”-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, тайлагнах, үр дүнг тооцох,
- Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлийн хяналтад олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хангах,

- Эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлж, эрүүл, аюулгүй хүнсний хангамжийг сайжруулах,
- Хүний хөгжилд соёл урлагийн үр нөлөөг нэмэгдүүлж, соёл уламжлалаа дээдэлдэг иргэнийг төлөвшүүлэх,
- Хүүхэд багачууд, иргэдэд хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлнэ.
- Төрийн үйлчилгээнд ухаалаг тогтвортой засаглалыг бэхжүүлж, чадахуйн зарчимд суурилсан хариуцлагатай шуурхай, нээлттэй, ил тод төрийн үйлчилгээг хүргэх,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- 1 Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- 2 Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөгдөхөөр батлагдсан,
- 3 Малын тоо толгойн албан татварын тухай хуультай холбоотойгоор 2020 онд Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 60 дугаар зүйлийн 60.2.8-д малын тоо толгойн албан татварын орлогыг зарцуулах заалт шинээр нэмэгдсэн,
- 4 Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах хэсэгт 2021 оны 7 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан,
- 5 УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- 6 Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолоор төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагыг төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан
- 7 Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах “Босго үнэ шинэчлэн батлах тухай” журмыг баталсан,
- 8 Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” шинэчлэгдэн батлагдсан,
- 9 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” шинэчлэгдэн батлагдсан,
- 10 Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,

- 11 Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн,
- 12 Аймгийн ТТЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан гэх мэт

Сүхбаатар сумын ТТЗ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант жилийн хугацаанд аймгийн СТХС-ээс дотоод хяналтын төлөвлөгөө, удирдамжийн хүрээнд төрийн сангийн 1-9 дүгээр сарын үйл ажиллагааг хамруулан шалгаж, илэрсэн алдаа зөрчлийг арилгах 11 зөвлөмж өгч, хэрэгжилтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан тооцохоор болсон байна.

Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитаар нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн дансны тухай, ТБОНӨХБАҮХА тухай, Төсвийн тухай хууль зэрэг хууль, эрхийн актуудыг 95 хувьтай хэрэгжүүлэн төсвийн хөрөнгийг зориулалтаар нь зарцуулж, өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангасан байна гэж дүгнэжээ.

Санхүүгийн хяналт шалгалт, аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах, таслан зогсоох зорилгоор 4 зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийн биелэлтийг 2022 оны 02 дугаар сарын 28-ны дотор ирүүлэх чиглэл өгсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул гэж дүгнэж байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 15,172,291.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 151,722.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 106,206.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн болно.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 485,425.4 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 607,761.5 мянган төгрөг болж, 122,336.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө		290.0	-
Банканд байгаа бэлэн мөнгө	485,425.4	607,471.5	122,046.1
Замд яваа мөнгөн хөрөнгө			
Хадгаламж			
<b>Дүн</b>	<b>485,425.4</b>	<b>607,761.5</b>	<b>122,336.1</b>

Эх сурвалж: Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан орон нутгийн ерөнхий орлогын дансанд 298,708.9 мянган төгрөг, ОНХС-ийн дансанд 130,321.1 мянган төгрөг, СХС-ийн дансанд 178,441.5 мянган төгрөг, ЗДТГ-ын арилжааны банкин дахь картын дансны үлдэгдэл 290.0 мянган төгрөг байна.

#### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 1,078,395.4 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 1,039,260.7 мянган төгрөг болж, 39,134.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	7,281.1	1,176.9	(6,104.2)
Татаас, санхүүжилтийн авлага	33,968.7	14,504.4	(19,464.3)
Зээлийн хүүгийн авлага	71,206.8	71,206.8	-
Байгууллагаас авах авлага	12,405.9	110,847.2	98,441.3
Хувь хүмүүсээс авах авлага	4,212.9	4,901.0	688.1
Зээлийн авлага	949,320.0	836,624.4	(112,695.6)
<b>Дүн</b>	<b>1,078,395.4</b>	<b>1,039,260.7</b>	<b>(39,134.7)</b>

Эх сурвалж Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Татаас санхүүжилтийн авлагын үлдэгдэл тайлант онд 19,464.3 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны 33,968.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан боловч тайлант онд ерөнхий боловсролын 1, 5 дугаар сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлж дараа онд буцаан олгохоор авлагаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Байгууллагаас авах авлагын үлдэгдэл 98,441.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Эмнэх, Номтхан өрхийн ЭМТ-ийн коронавирусын халдвараар хөнгөн хэлбэрээр өвчилж, гэрээр эмчлэгдэх үед олгосон эмийн багцын санхүүжилт ЭМДЕГ-аас дутуу орж ирснээс шалтгаалсан байна.

СХС-ийн зээлийн авлагын үлдэгдэл тайлант онд 112,695.6 мянган төгрөгөөр буурсан нь СХС-ийн зээлийн мэдээлэл Монгол банкны мэдээллийн санд орсноор иргэн, ААН-ын зээлийн эргэн төлөлт нэмэгдсэн болон шүүхийн шийдвэрийг үндэслэн зээлдэгчтэй эвлэрлийн гэрээ байгуулан хамтран ажилласны үр дүнгээс шалтгаалсан байна.

### **Аудитын илрүүлэлт:**

#### **3-р цэцэрлэг:**

➤ 413.7 мянган төгрөгийн нийгмийн даатгалын байгууллагаас авах авлагыг дутуу тусгасан.

#### **3-р сургууль:**

➤ Тайлант онд санхүүгийн байдлын тайланд 211.5 мянган төгрөгийн хүнсийн материалын авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, бүртгэл тайланд тусгаагүй байна.

#### **Спорт сургууль:**

➤ Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас тайлант онд ХХОАТ-ын 1,284.4 мянган төгрөгийн авлага үүсгэсэн.

#### **ТТЗ:**

➤ Орон нутгийн ерөнхий орлогоос СХС-аас олгох зээлийг төлөвлөснөөс 1,100.0 мянган төгрөгөөр илүү санхүүжүүлсэн.

➤ Өмнөх оны татаас санхүүжилтийн авлагын 33,968.7 мянган төгрөгийн устгах бичилтийг хийгээгүй тайлагнасан.

#### **ИТХ:**

➤ Төлбөр тооцоог хянаагүйгээс 311.4 мянган төгрөгийн цалин илүү олгож, авлага үүсгэсэн.

#### **ЗДТГ:**

➤ Төлбөр тооцоог хянаагүйгээс НДШ-д 209.5 мянган төгрөгийг илүү шилжүүлж, авлага үүсгэсэн.

#### **Бэлчир бүсийн ойн анги:**

➤ Төлбөр тооцоог хянаагүйгээс үнэт цаасны төлбөрт 40.2 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн.

### Эмнэх өрхийн ЭМТ

- Ажилчидтай холбоотой цалингийн тооцооллыг хянаагүйгээс 688.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 1,164,380.7 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 1,383,305.8 мянган төгрөг болж, 218,925.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	93,334.7	135,396.7	42,062.0
Эм боох материал	10,231.1	10,406.6	175.5
Бичиг хэргийн материал	2,728.5	6,861.3	4,132.8
Аж ахуйн материал	577,774.5	623,149.1	45,374.6
Сэлбэг хэрэгсэл	2,175.0	2,929.0	754.0
Түлш, шатах тослох материал	4,599.8	4,354.0	(245.8)
Барилгын засварын материал	6,494.3	4,252.3	(2,242.0)
Хүнсний материал	7,897.4	8,502.9	605.5
Бусад хангамжийн материал	454,152.4	575,403.9	121,251.5
Биологийн хөрөнгө	-	7,000.0	7,000.0
Мал амьтад	4,993.0	5,050.0	57.0
<b>дүн</b>	<b>1,164,380.7</b>	<b>1,383,305.8</b>	<b>218,925.1</b>

Эх сурвалж: Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТТЗ-ийн бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс материаллаг хэмжээгээр өсөхөд тусгай зориулалтын материал, аж ахуйн материал, бусад хангамжийн материалын дансны үлдэгдлүүд нөлөөлсөн байна. Үүнд:

- Тусгай зориулалтын дансны үлдэгдэл 42,062.0 мянган төгрөгөөр өссөн нь Ковид- 19 цар тахалтай холбоотойгоор өрхийн ЭМТ-ийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай хамгаалах хэрэгсэл, ариутгал, эм боох материалын үлдэгдлээс шалтгаалсан байна.
- Аж ахуйн материалын дансны үлдэгдэл 45,374.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь өрхийн ЭМТ-ийн албан хаагчдын нормын хувцас, сургууль, цэцэрлэгүүдийн хүнсний материал, аж ахуйн материал, хангамжийн материалын зарцуулагдаагүй үлдэгдлээс шалтгаалсан.
- Бусад хангамжийн материалын дансны үлдэгдэл 121,251.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь БШУЯ-аас спортын сургууль, ерөнхий боловсролын сургуулиудад биологи, хими, физикийн кабинетын сургалтын хэрэглэгдэхүүн нийлүүлсэн болон төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн хангамжийн материалын зарцуулагдаагүй үлдэгдэл зэргээс голлон шалтгаалсан байна.

### Аудитын илрүүлэлт:

1. Дараах байгууллагууд нь бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна Үүнд:

- ИТХ нь 7,499.7 мянган төгрөгийн,
- ЗДТГ нь 43,716.5 мянган төгрөгийн,
- Эмнэх Өрхийн эрүүл мэндийн төв нь 16,564.1 мянган төгрөгийн,
- Номтхан Өрхийн эрүүл мэндийн төв нь 10,536.0 мянган төгрөгийн
- Бэлчир бүсийн ойн анги 10,000.0 мянган төгрөгийн,
- 1-р цэцэрлэг нь 35,329.7 мянган төгрөгийн
- 2-р цэцэрлэг нь 106,964.2 мянган төгрөгийн
- 3-р цэцэрлэг нь 120,411.9 мянган төгрөгийн
- 4-р цэцэрлэг нь 99,263.0 мянган төгрөгийн
- 5-р цэцэрлэг нь 80,142.3 мянган төгрөгийн
- 6-р цэцэрлэг нь 8,897.9 мянган төгрөгийн
- 7-р цэцэрлэг нь 29,304.1 мянган төгрөгийн
- 1-р сургууль нь 91,546.9 мянган төгрөгийн
- 2-р сургууль нь 145,977.4 мянган төгрөгийн
- 3-р сургууль нь 135,888.4 мянган төгрөгийн
- 4-р сургууль нь 136,500.9 мянган төгрөгийн
- 5-р сургууль нь 69,409.9 мянган төгрөгийн
- 6-р сургууль нь 75,405.2 мянган төгрөгийн
- Спорт сургууль нь 62,253.7 мянган төгрөгийн

#### 2-р цэцэрлэг:

- Хүнсний материалын тайлан нь анхан шатны баримтын бүрдэлгүй, тогоочийн материалын захиалгад нэг хүүхдийн норм, норматив бичигдээгүй, хоолны цэсийг үндэслэн материалын зарцуулалтыг хийгээгүй.

#### 6-р цэцэрлэг:

- Тайлант оны эхний үлдэгдэлд тайлагнасан 224.7 мянган төгрөгийн мах /сүүл, өөх/-ыг жилийн турш хэрэглэлгүйгээр эцсийн үлдэгдлээр тайлагнасан.

#### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл /анхны өртгөөр/ 26,638,751.9 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 30,211,036.9 мянган төгрөг болж, 3,572,285.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	19,575,825.3	22,268,917.1	2,693,091.8
Авто-тээврийн хэрэгсэл	247,165.5	218,745.5	(28,420.0)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,628,880.7	2,861,994.6	233,113.9
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,505,595.8	1,589,604.6	84,008.8
Зам, гүүрийн байгууламж	72,853.7	157,545.8	84,692.1
Бусад үндсэн хөрөнгө	602,049.5	1,044,904.5	442,855.0
Ном	175,439.0	180,355.6	4,916.6
Програм хангамж	60,596.5	83,739.3	23,142.8
Бусад биет бус хөрөнгө	1,770,345.9	1,805,229.9	34,884.0
<b>дүн</b>	<b>26,638,751.9</b>	<b>30,211,036.9</b>	<b>3,572,285.0</b>

Эх сурвалж: Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос /анхны өртгөөр/ 3,572,285.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 362,246.4 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан, үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авсан 3,590.0 мянган төгрөг, хандиваар авсан 1,620,668.9 мянган төгрөг, 2,954,446.2 мянган төгрөгийн "0" үлдэгдэлтэй хөрөнгийг дахин үнэлсэн зэрэг нийт 4,940,951.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 40 дүгээр тогтоолоор 400,605.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 167,868.1 мянган төгрөгийг байгууллага хооронд шилжүүлсэн, ашиглалтын хугацаа дууссан 800,193.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, 213,572.8 мянган төгрөгөөр үнэлэн, данс бүртгэлд тусгасан зэргээс шалтгаалсан байна.

Барилга байгууламжийн дансанд материаллаг хэмжээний өөрчлөлт орсон нь АНУ-ын ЭСЯ-ны хөрөнгө оруулалтаар 1,273,007.8 мянган төгрөгийн өртөг бүхий 50 хүүхдийн иж бүрэн цэцэрлэгийн барилгыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан болон 1,430,535.2 мянган төгрөгийн өртөг бүхий барилгатай 8-р цэцэрлэг шинээр ашиглалтад орсоноос шалтгаалсан байна.

Бусад үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 442,855.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 7-р цэцэрлэгт БСШУЯ-аас нийлүүлэгдсэн 100,544.6 мянган төгрөгийн дизель генератор, АНУ-ын ЭСЯ-ны хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 306,055.2 мянган төгрөгийн цахилгаан болон дулааны узель, төмөр хашаа, гүний худаг, бохирын танк зэрэг 406,599.8 мянган төгрөгөөр, 4-р цэцэрлэгт ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 29,835.5 мянган төгрөгийн тоглоомын талбай зэрэг хөрөнгүүдийг үнэ төлбөргүй хүлээн авч орлогоор бүртгэснээс голлон шалтгаалсан байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

##### **ЗДТГ, Эмнэх өрхийн ЭМТ:**

- 2021 онд шинээр орлогод авсан **40,811.8** мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох ашиглалтын жилийг оруулаагүй /ЗДТГ нь 26,811.8 мянган төгрөг, Эмнэх өрхийн ЭМТ нь 14,000.0 мянган төгрөг/ ,
- ЗДТГ нь холбогдох мэргэжлийн байгууллагын акт, дүгнэлт, ТӨБЗГ, аймгийн ОНӨГ-ын шийдвэр бусад шаардлагатай баримт материалын үндэслэлгүйгээр 10,451.3 мянган төгрөгийн өртөг бүхий чулуун склад, 28,420.0 мянган төгрөгийн авто машин / *тоёота марк-2, прадо-95, ачааны самосмал* / зэрэг нийт **38,871.3** мянган төгрөгийн үл хөдлөх хөрөнгө болон тээврийн хэрэгслийг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 40 дүгээр тогтоолоор данс бүртгэлээс хассан.
- **1-р цэцэрлэг:**
- Тайлант онд байгууллагын эзэмшиж байгаа газарт 2,122.6 мянган төгрөгийн элэгдэл байгуулан үр дүнгийн тайланд тусгасан.

##### **3-р цэцэрлэг:**

- Үр дүнгийн тайланд 22,551.8 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан.

#### **3.5.5 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 40,164.0 мянган төгрөг байсан бол эцсийн

үлдэгдэл 108,631.2 мянган төгрөг болж, 68,467.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	519.2	1,570.6	1,051.4
Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,555.4	3,730.2	1,174.8
Байгууллагад төлөх өглөг	36,213.4	2,839.8	(33,373.6)
Хувь хүмүүст төлөх өглөг	876.0	100,490.6	99,614.6
<b>дүн</b>	<b>40,164.0</b>	<b>108,631.2</b>	<b>68,467.2</b>

Эх сурвалж: Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөр өссөн нь 2 өрхийн эрүүл мэндийн төвийн covid-19 цар тахлын гэрийн эмчилгээний эмийн багц бэлтгэхтэй холбоотой өр төлбөр 97,094.5 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

### Аудитын илрүүлэлт:

#### 1-р цэцэрлэг

➤ Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан тооцоог хянан баталгаажуулаагүйгээс хүнсний материалын 213.8 мянган төгрөгийн авлага, цахилгааны 622.6 мянган төгрөгийн, цэвэр бохир усны 340.7 мянган төгрөгийн зэрэг нийт 1,177.1 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн.

#### 4-р сургууль:

➤ Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан тооцоог хянан баталгаажуулаагүйгээс ХХОАТ-ын 583.7 мянган төгрөг, цалингийн 402.9 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн 91.8 мянган төгрөг, ажиллагсадтай холбоотой 198.0 мянган төгрөг зэрэг нийт 1,276.4 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн.

#### Спорт сургууль:

➤ Тайлант онд санхүүгийн байдлын тайланд хөдөлмөрийн чадвараа 70 хувь алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэний 1,284.4 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөгийг бүртгэлд тусгаагүй.

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 24,980,075.5 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 28,814,301.9 мянган төгрөг болж, 3,834,226.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,106,760.4	9,106,760.4	-
Өмнөх үеийн үр дүн	6,505,838.6	6,778,071.1	272,232.5
Тайлант үеийн үр дүн	267,461.7	3,834,226.3	3,566,764.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,100,014.8	9,095,244.1	(4,770.7)
<b>дүн</b>	<b>24,980,075.5</b>	<b>28,814,301.9</b>	<b>3,834,226.4</b>

Эх сурвалж: Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5,685,528.0 мянган төгрөг болж 3,834,226.4 мянган төгрөгөөр өссөн нь 7 ба 8 дугаар цэцэрлэгийн шинээр ашиглалтад орсон барилгаас голлон шалтгаалсан байна.

### 3.5.7 Орлогын данс

Орлогын данстай холбоотой 12,266.9 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

#### Аудитын илрүүлэлт:

##### 2-р сургууль:

- Тусгай зориулалтын шилжүүлгийн орлогыг 11,666.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

##### 5-р сургууль:

- Үр дүнгийн тайланд нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн дээд шатны төсвийн захирагчаас хоолны зардалд олгосон 599.7 мянган төгрөгийн орлогыг дутуу тайлагнасан.

### 3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 137,300.6 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

#### Аудитын илрүүлэлт:

##### 1-р цэцэрлэг:

- Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа багш Ё.Нарантуяад гэрээнд заагаагүй 1,150.3 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс бодож олгосон.

##### 2-р цэцэрлэг:

- Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс цалингийн зардлаас 613.0 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд гүйлгэн зарцуулсан.

##### 3-р цэцэрлэг:

- Нийгмийн даатгалын тайланд 4 ажилтны 1,680.0 мянган төгрөгийн цалинг даатгуулагчийн төрлийг буруу тайлагнасан, хүүхэд асрах чөлөөтэй байгаа 5 ажилтны шимтгэлийг 2,100.0 мянган төгрөгөөр илүү тайлагнаж, шимтгэл төлсөн байна.
- Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 540.2 мянган төгрөгийг цалингийн зардлаас санхүүжүүлсэн байна.
- Эрх бүхий албан тушаалтны тушаал, шийдвэргүйгээр багш Ж.Алтанхуягт 206.4 мянган төгрөгийн, Л.Уянгад 88.6 мянган төгрөгийн, Ц.Болорцэцэгт 41.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал, багш Я.Нарантуяад 83.1 мянган

төгрөгийн илүү цагийн хөлс зэрэг нийт 419.4 мянган төгрөгийн нэмэгдэл хөлсийг илүү тооцож олгосон.

- Тээвэр шатахууны 50.0 мянган төгрөгийн зардлыг түлш, халаалтын зардлаар тайлагнасан.

#### 4-р цэцэрлэг:

- Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс цалингийн зардлын 1,134.7 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас зардлаас санхүүжүүлсэн байна
- Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалан багш Ц.Мөнхцацралд 132.9 мянган төгрөгийн, туслах багш У.Удвалцэцэгт 47.3 мянган төгрөгийн хөдөө орон нутагт ажилласны нэмэгдлийг илүү тооцож олгосон.

#### 6-р цэцэрлэг:

- Цэцэрлэгийн хүүхдийн хоолны нэг хүүхдэд ногдох нормативыг хэтрүүлснээс 667.7 мянган төгрөг илүү зарцуулсан

#### 8-р цэцэрлэг:

- Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдэл олгосон.

#### 1-р сургууль:

- Улирлын амралттай хугацаанд бус 8 дугаар сард багш нарт анги даалтын нэмэгдэлд 1,862.8 мянган төгрөгийг бодож олгосон.

#### 2-р сургууль:

- Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс нэг удаагийн тэтгэмжийн 338.1 мянган төгрөгийг цалингийн зардлаас санхүүжүүлсэн.
- Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалан багш Г.Түмэндэлгэрт 187.0 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл, багш Т.Нямсүрэнд 84.3 мянган төгрөгийн илүү цагийн хөлс зэрэг нийт 271.3 мянган төгрөгийг илүү бодож олгосон.
- Тайлант онд үр дүнгийн тайланд 26,730.0 мянган төгрөгийн элэгдэл дутуу тусгасан.

#### 3-р сургууль:

- Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс нэг удаагийн тэтгэмжийн 570.1 мянган төгрөгийг цалингийн зардлаас санхүүжүүлсэн.
- Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалан бичиг хэрэг, архивын ажилтан П.Уранчимэгт 134.3 мянган төгрөгийн төрийн алба хаасан хугацааны, нийгмийн ажилтан Б.Золбоод 340.0 мянган төгрөгийн хавсран ажилласны нэмэгдэл хөлс зэрэг нийт 928.7 мянган төгрөгийг илүү бодож олгосон.
- Захирал Л.Уянгад 454.4 мянган төгрөгийн ХЧТА-ны тэтгэмжтэй давхардуулан цалин олгосон.

#### 4-р сургууль:

- Эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүйгээр 4 багшид 127.4 мянган төгрөгийн кабинетын нэмэгдэл цалин бодож олгосон.
- Анхан шатны баримт буюу нэмэгдэл хөлс тооцож олгох хуудасгүйгээр сургалтын менежер А.Батзаяад 127.5 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс тооцож олгосон.

#### 5-р сургууль:

- Улирлын амралттай хугацаанд бус 8 дугаар сард багш нарт анги даалтын нэмэгдэлд 513.9 мянган төгрөгийг бодож олгосон.
- Үр дүнгийн тайланд нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн дээд шатны төсвийн захирагчаас бичиг хэргийн зардалд олгосон 175.0 мянган төгрөгийг дутуу тайлагнасан.

#### Спорт сургууль:

- Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс нэг удаагийн тэтгэмжийн 1,447.4 мянган төгрөгийг цалингийн зардлаас санхүүжүүлсэн.
- Нягтлан бодогч Б.Одонтуюад "Захиргаа аж ахуйн нэгдлийн ахлагч"-ийн нэмэгдэлд 224.8 мянган төгрөгийн цалин илүү бодож олгосон.

#### ИТХ, ЗДТГ:

- Зардлын төсөв, тооцоо, судалгаагүй, гүйцэтгэлийн баримтгүй, жолоочийн тооцооны хуудсыг холбогдох маягт, аргачлалаар хөтлөөгүй, шатахууны норм, нормативын тооцоололгүй зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр **ЗДНХ-өөс / 2021 оны А/31, А/54, А/96, А/185, А/194, А/287 дугаар захирамжаар /** ковид-19 халдвараар өвчилсөн иргэдэд үйлчилгээ үзүүлэх гэрийн эргэлийн багт дэмжлэг үзүүлэх, батлагдсан тохиолдлын ойрын хавьтлаас шинжилгээ авах, вакцинжуулалт хийх, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зэрэг арга хэмжээнүүдийн нийт 93,846.2 мянган төгрөгийн зардлын гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна.
- ИТХ нь анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ИТХ-ын 2021 оны үйл ажиллагааны тайлан мэдээлэл бүхий 1000 ширхэг сэтгүүл, гарын авлага, тогтоол шийдвэрийн эмхэтгэл хийлгэхэд 3,050.0 мянган төгрөг, сумын хамтарсан багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж зөвлөн туслах үйлчилгээнд 1,800.0 мянган төгрөг, жолоочийн тооцооны хуудсыг холбогдох маягт, аргачлалаар хөтлөөгүй, шатахууны норм, нормативын тооцоололгүй 6,046.2 мянган төгрөг зэрэг нийт 10,896.2 мянган төгрөгийн зарлагын ажил гүйлгээг гүйцэтгэж, шууд зардлаар тайлагнасан.
- Өмч хамгаалах зөвлөлөөр эдэлгээний хугацаа, зайлшгүй хийх шаардлагатай эсэх талаарх техникийн комиссын дүгнэлт гаргалгүйгээр автомашины засвар үйлчилгээнд ЗДТГ 9,322.0 мянган төгрөг, ИТХ 2,344.5 мянган төгрөг нийт **11,666.5** мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийг олгосон

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Сүхбаатар сумын ИТХ-ын “2021 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2021 оны 21 дүгээр тогтоолоор 1,139,932.0 мянган төгрөгийн татварын орлого, 217,644.2 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 1,380,886.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 101.7 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Татварын орлого</b>	<b>1,139,932.0</b>	<b>1,125,536.1</b>	<b>(14,395.9)</b>	<b>98.7</b>
Үйл ажиллагааны орлого	200,000.0	76,440.3	(123,559.7)	38.2
Хөрөнгийн орлого	572,612.0	511,985.2	(60,626.8)	89.4
Хөрөнгө борлуулсны орлого	100,000.0	277,971.3	177,971.3	278.0
Малын тоо толгойн албан татвар	-	12,976.8	-	-
Бууны албан татвар	7,140.0	7,296.6	156.6	102.2
Улсын тэмдэгтийн хураамж	126,000.0	92,939.9	(33,060.1)	73.8
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	2,500.0	801.5	(1,698.5)	32.1
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	95,000.0	66,276.6	(28,723.4)	69.8
Газрын дуудлага худалдааны орлого	36,280.0	27,503.3	(8,776.7)	75.8
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	200.0	20.0	(180.0)	10.0
Байгалийн ургамал ашигласны төлбөр	200.0	25.0	(175.0)	12.5
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр		595.9	595.9	-
<b>Татварын бус орлого</b>	<b>217,644.2</b>	<b>255,350.3</b>	<b>37,706.1</b>	<b>117.3</b>
Хүү, торгуулийн орлого	185,644.2	272,654.0	87,009.8	146.9
Бусад орлого	32,000.0	33,399.7	1,399.7	104.4
<b>Нийт дүн</b>	<b>1,357,576.2</b>	<b>1,380,886.4</b>	<b>23,310.2</b>	<b>101.7</b>

Эх сурвалж: Сүхбаатар сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд хөрөнгө борлуулсны орлого 177,971.3 мянган төгрөг, бууны албан татвар 156.6, хүү торгуулийн орлого 87,009.8 мянган төгрөг, бусад орлого 1,399.7 мянган төгрөгийн орлогыг тус тус давж биелүүлсэн байна. Төлөвлөөгүй малын тоо толгойн албан татвар 12,976.8 мянган төгрөг, ус рашааны нөөц ашигласны төлбөр 595.90 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Үйл ажиллагааны орлого 123,559.7 мянган төгрөгөөр, хөрөнгийн орлого 60,626.8 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамж 33,060.1 мянган төгрөгөөр, хог хаягдлын хураамж 28,723.4 мянган төгрөгөөр, газрын дуудлага худалдааны орлого 8,776.7 мянган төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр 180.0 мянган төгрөгөөр, байгалийн ургамал ашигласны төлбөр 175.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

### Давж биелсэн орлогууд:

- ✓ **Хөрөнгийн борлуулсны орлого:** Иргэний үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого нэмэгдсэнээс шалтгаалсан.
- ✓ **Хүү, торгуулийн орлого:** Зөрчлийн тухай хуулийн хүрээнд торгууль, нөхөн төлбөрийн орлого болон татварын торгууль, алдангийн орлого өмнөх онуудаас нэмэгдсэнээс шалтгаалсан.

### Тасарсан орлогууд:

- ✓ **Хөрөнгийн орлого:** Орлогын төлөвлөлтийг үндэслэл муутай тооцсоноос тасарсан.
- ✓ **Үйл ажиллагааны орлого:** Ковид-19 цар тахлаас үүдэн аж ахуй нэгж байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн орлогын эх үүсвэр буурснаас шалтгаалсан.
- ✓ **Улсын тэмдэгтийн хураамж:** Ковид-19 цар тахал гарч бүх нийтийн хатуу хөл хорио тогтоосны улмаас төрөөс иргэдэд үйлчилдэг бүх төрлийн төрлийн үйл ажиллагаа зогссоноос шалтгаалсан.
- ✓ **Хог хаягдлын үйлчилгээний хураамж:** Ковид-19 цар тахал гарсны улмаас Засгийн газраас хог хаягдлын хураамжийг хөнгөлсөн боловч Засгийн газраас орж ирсэн нөхөн төлбөр 2020 оны мөн үеийн гүйцэтгэлээр олгосон нь төлөвлөгөө биелээгүй гол шалтгаан болсон.
- ✓ **Ан амьтны нөөц ашигласны төлбөр:** Ковид-19 цар тахлын улмаас иргэд ан, амьтан агнах зөвшөөрөл авах үйл ажиллагаа зогссоноос шалтгаалсан.
- ✓ **Түгээмэл тархацтай ашигт малтмал:** Орлогын төлөвлөгөөг хэт өндөр төлөвлөснөөс тасарсан байна.
- ✓ **Газрын дуудлага худалдаа:** 2020 оны 11 дүгээр сараас газрын даамал газрын төлбөр төвлөрүүлдэг байсныг татварын цахим төлбөрийн системд холбосонтой холбоотойгоор буурсан зэргээс голлон шалтгаалсан байна.

### **Төсвийн төлөвлөлт**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 13,584,598.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 13,584,598.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийг сумын ИТХ-ын 2020 оны 08 дугаар тогтоолоор төсвийн орлогыг 1,357,576.2 мянган төгрөг, байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 16,125.0 мянган төгрөг, урьд оны эхний үлдэгдлээс санхүүжих 143,592.2 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 1,369,016.4 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 258,572.8 мянган төгрөг ОНХС-ийн эхний үлдэгдлээс 98,642.5 мянган төгрөг, ТЗШ-ийн байгууллагын санхүүжилтийг 10,139,072.8 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 202,000.0 мянган төгрөг, нийт 13,584,598.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын “Аймгийн 2021 оны тодотгосон төсөв батлах тухай” 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 16 дугаар тогтоолоор тус суманд аймгаас олгох

санхүүгийн дэмжлэгийг 237,908.6 мянган төгрөгөөр, ТЗШ-ийн санхүүжилтийг 795,744.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Дээрх тогтоолыг үндэслэн сумын ИТХ-ын 2021 оны тодотгосон төсөв батлах тухай 21 дугаар тогтоолоор урд оны үлдэгдлээс 144,476.0 мянган төгрөгийг нэмж тодотгон нийт төсвийн орлого, зарлагыг тус бүр 1,178,129.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 14,762,727.2 мянган төгрөг болгон өөрчилж баталсан байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 11 хөтөлбөрт зориулан 14,762,727.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас аймгийн Засаг даргын 2021 оны А/372 дугаар захирамжаар ТЗШ-ийн байгууллагуудын төсөвт зохицуулалт хийгдэж тус сумын ТЗШ-ийн байгууллагуудаас нийт 79,295.6 мянган төгрөгийг хасаж 10,855,521.9 мянган төгрөг болгосноос шалтгаалж батлагдсан төсөв **14,683,431.6** мянган төгрөг болж өөрчлөгдсөн байна.

### Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг 1,606,925.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 1,730,460.7 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 258,572.8 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 10,855,521.9 мянган төгрөг, төсөвт байгууллагуудын өөрийн орлого 17,255.6 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 214,695.6 мянган төгрөг зэрэг нийт 14,683,431.6 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **13,939,221.2** мянган төгрөг буюу 94.9 хувьтай тайлагнагдсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 94,485.34 мянган төгрөгөөр, ажил олгогчийн НДШ-ийн зардал 35,913.5 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 241,043.8 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 4,976.8 мянган төгрөгөөр, нормативт зардал 99,142.3 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 348.8 мянган төгрөгөөр, томилолтын зардал 835.7 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 3,865.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 1,468.5 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 8,959.0 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардал 155,170.8 мянган төгрөг, эргэн төлөгдөх зээл 98,000.0 мянган төгрөг, өөр тус тус хэмнэлттэй тайлагнагдсан байна.

Тайлант онд сумын хөрөнгө оруулалтаар нийт 8 төсөл, арга хэмжээнд 56,097.6 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 31,247.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 24,849.8 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь ковид-19 цар тахлын улмаас 3 төсөл, арга хэмжээг улсын комиссын актаар ашиглалтад оруулах ажил оройтож, он дамжсанаас шалтгаалсан байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 6 төсөл, арга хэмжээнд 233,421.5 мянган төгрөг, 2020 оны 6 төсөл арга хэмжээний 98,642.5 мянган төгрөг, нийт 332,064.0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж,

гүйцэтгэлээр 201,743.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 130,321.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь ковид-19 цар тахлын улмаас төсөл, арга хэмжээг улсын комиссын актаар ашиглалтад оруулах ажил оройтож он дамжсанаас шалтгаалсан байна.

#### Нэмэлт төсөв:

Хандив тусламжаар 8,000.0 мянган төгрөг, аймгийн ЗДНХ-өөс 49,669.5 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 191,035.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 109,218.5 мянган төгрөг, ЭМДС-аас 211,622.6 мянган төгрөг зэрэг нийт 569,546.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалингийн зардалд 8,869.3 мянган төгрөг, НДШ-ийн зардалд 994.7 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 13,065.7 мянган төгрөг, нормативт зардалд 89,246.2 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 15,417.2 мянган төгрөг, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 98,861.4, бараа үйлчилгээний бусад зардалд 297,630.2 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 18,186.5 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 27,275.1 мянган төгрөг зэрэг нийт **569,546.3** мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

**3.7.1** ЗДТГ-ын бусад авлага дансанд 2005 онд үүссэн гэх байгууллагаас авах 4.106.0 мянган төгрөгийн, хувь хүнээс авах 2,517.6 мянган төгрөгийн эзэн холбогдогч нь тодорхойгүй, насжилт өндөртэй авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

**3.7.2** ЗДТГ, Бэлчир бүсийн Ойн анги нь төрийн албан хаагчдад улирлын мөнгөн урамшууллыг жилийн ажлын дүнгээр үнэлж 60-90 хувиар тооцож олгосон байгаа нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна" гэж заасантай нийцэхгүй байна. Цаашид үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох журмын хэрэгжилтийг ханган ажиллах шаардлагатай байна.

**3.7.3** Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн "Эд хөрөнгө актлах тухай" 2021 оны 40 дүгээр тогтоолоос данснаас хассан хөрөнгийн дүн 2,408.1 мянган төгрөгөөр дутуу байгаа бөгөөд Өмч хамгаалах зөвлөлийн хурлын тэмдэглэл, устгах хөрөнгийн фото зураг зэрэг баримтгүйгээр ЗДТГ 68,847.8 мянган төгрөг, 2-р сургууль 85,912.2 мянган төгрөг, 5-р сургууль 6,934.2 мянган төгрөг, 6-р сургууль 79,083.2 мянган төгрөг, 1-р цэцэрлэг 8,017.4 мянган төгрөг, 2-р цэцэрлэг 11,689.3 мянган төгрөг, 4-р цэцэрлэг 7,240.4 мянган төгрөг, 6-р цэцэрлэг 3,618.3 мянган төгрөг, 7-р цэцэрлэг 18,816.3 мянган төгрөг нийт **290,159.1** мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хассан байна. Цаашид хөрөнгө актлах, данснаас хасах тухай гарсан тогтоол, шийдвэрийн

хэрэгжилтийг бүрэн хангах, актлах хөрөнгүүдийг нотлох баримтаар баталгаажуулж байх нь зүйтэй юм.

**3.7.4** Сумын 2021 оны төсөв баталсан ИТХ-ын 2020 оны 08 дугаар тогтоол болон төсөвт тодотгол хийсэн 2021 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан хөрөнгө оруулалтын жагсаалтад өмнөх оноос шилжиж ирсэн 26,597.5 мянган төгрөгийн төсөл арга хэмжээний дүн 5,655.9 мянган төгрөгөөр дутуу болон 1 төсөл арга хэмжээний нэр тодорхойгүйгээс гэрээний зөрүү үлдэгдэл гэж баталсан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

**3.8.1** Ковид- 19 цар тахалтай холбоотойгоор тавилга, техник, тоног төхөөрөмжийн нийлүүлэлт хангалтгүйгээс шууд худалдан авах босго үнээс давсан худалдан авалтуудыг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна.

**3.8.2** Ковид- 19 цар тахалтай холбоотойгоор иргэд, аж ахуйн нэгжээс хандивласан 8,000.0 мянган төгрөгийн орлогыг сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар авч зарцуулсан байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

*Хүснэгт: 8 ТТЗ-ийн харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл*

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	ТТЗ	155	138	17	-
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	151	90	61	-
3	Засаг даргын Тамгын газар	151	134	10	7
4	Эмнэх ЭМТ	4	4	-	-
5	Номтхан ЭМТ	4	4	-	-
6	8-р цэцэрлэг	48	47	1	-
7	Бэлчир бүсийн ойн анги	151	150	1	-
	<b>Нийт дүн</b>	<b>664</b>	<b>567</b>	<b>90</b>	<b>7</b>

ТТЗ-ийн түвшинд нийт давхардсан тоогоор мэдээлбэл зохих 664 мэдээллээс 567 мэдээллийг хугацаанд нь, 90 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол огт мэдээлээгүй 7 мэдээлэл байна. Үүнээс 8 дугаар цэцэрлэг тайлант оны 9 дүгээр сараас шинээр үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй холбоотойгоор 9 дүгээр сараас хойш мэдээлэх нийт 48 мэдээллээс тооцсон болно.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /сумын Засаг даргын түвшинд мэдээлбэл зохих болон ИТХ, ЗДТГ/- нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Хүснэгт № 9 ТТЗ-ийн харьяа байгууллагуудын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэмнэлт

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Тавилга, эд хогшил худалдаж авсан	Хэмнэсэн хувь
1	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	155,269.7	154,886.6	500.0	0.3
2	Сумын Засаг даргын Тамгын газар	1,478,023.5	1,443,292.7	2,080.0	2.4
3	Бэлчир бүсийн ойн анги	45,173.5	45,173.5		
	<b>Нийт дүн</b>	<b>1,678,466.7</b>	<b>1,643,352.8</b>	<b>2,580.0</b>	<b>2.1</b>

ТТЗ-ийн харьяа дээрх 3 байгууллагын тайлант оны үйл ажиллагаанд 1,678,466.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,643,352.8 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 2.1 хувиар хэмнэсэн болон 2,580.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, худалдан авсан нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: "... батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.4-т: ".....бусад автомашин, албан конторын тавилга, ... худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 784.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 19,966.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 7 албан шаардлага, 34,474.2 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт: 9 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	784.7	1	784.7			100
Албан шаардлага	7	19,966.0	7	19,966.0			100
Зөвлөмж	3	34,474.2	2	34,474.2	1	-	66.7
<b>Нийт</b>	<b>11</b>	<b>55,224.9</b>	<b>10</b>	<b>55,224.9</b>	<b>1</b>		<b>90.9</b>

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 дэх "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа,

зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

**3.11.1** Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХС, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан бөгөөд харин төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг ОНХС-ийн зарцуулалтын үр дүн сэдэвт аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

**3.11.2** СХС-аас олгосон зээлийн төсөл сонгон шалгаруулалт, зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу хийгдэж байгаа болон хугацаа хэтэрсэн, насжилт өндөртэй авлагыг барагдуулах арга хэмжээтэй холбоотой асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй байна.

**3.11.3** Бэлчир бүсийн Ойн ангийн санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч ойн ангиас олгосон гарал үүслийн гэрчилгээ, мод бэлтгэх эрхийн бичгийн зарцуулалтын тайланг дараагийн аудитаар тулган баталгаажуулах шаардлагатай.

## 4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагчийн 20 төсвийн байгууллага, орон нутгийн төсөл, сангийн 2, нийт 22 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 14 байгууллагад дүгнэлт гаргаж, 6 байгууллага, 2 төсөл сан түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа 14 байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Сүхбаатар сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,633,354.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 65,320.3 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 3,429.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 218,091.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 1,346,513.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

**ТТЗ-ийн түвшний аудитаар нийт 352,168.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 290.0 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 211,084.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 140,794.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.**

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

**140,794.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.**

**4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- ЗДТГ нь байгууллагын жижиг мөнгөн кассын арилжааны банкин дахь 290.0 мянган төгрөгийн үлдэгдлийг тайлагнаагүй алдааг залруулав.

**4.2 Албан шаардлага**

**4.2.1** Урьд оны үлдэгдлээс зайлшгүй шаардлага үүсээгүй байхад сумын ЗДТГ, багуудад багаж, техник хэрэгсэл, тавилга худалдан авах болон урсгал засварын зардлыг нийт 31,152.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн тодотгол хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.2 дахь “Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ”, 34.2.2: “Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад төсөвт тодотгол хийхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

**4.2.2** Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс дараах байгууллага, хөтөлбөрүүдэд авлага, өр төлбөр үүсгэсэн болон батлагдсан төсөв хэтрүүлсэн, нягтлан бодох бүртгэлийн бичилтийг буруу гүйцэтгэсэн зэрэг нийт 36,317.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж **авлага**, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог **хянах**...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- СХС-аас олгох зээлийг төлөвлөснөөс 1,100.0 мянган төгрөгөөр санхүүжүүлж, батлагдсан төсвийг хэтрүүлсэн,
- Өмнөх оны татаас санхүүжилтийн авлагын 33,968.7 мянган төгрөгийн устгах бичилтийг хийгээгүй тайлагнасан,
- ИТХ нь цалин илүү олгож 311.4 мянган төгрөгийн авлага үүсгэсэн,
- ЗДТГ нь НДШ-д 209.5 мянган төгрөгийг илүү шилжүүлж, авлага үүсгэсэн,
- Бэлчир бүсийн Ойн анги нь үнэт цаасны төлбөрт 40.2 мянган төгрөгийг илүү шилжүүлж, авлага үүсгэсэн,
- Эмнэх баг өрхийн эрүүл мэндийн төв нь цалингийн 688.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн.

хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- ЗДТГ нь зардлын төсөв, тооцоо, судалгааг урьдчилан тооцоогүй, гүйцэтгэлийн баримтууд бүрдүүлээгүй болон жолоочийн тооцооны хуудсыг холбогдох маягт аргачлалаар хөтлөөгүй, шатахууны норм нормативын тооцоололгүй зэргээр ЗДНХ-өөс / 2021 оны А/31, А/54, А/96, А/185, А/194, А/287 дугаар захирамжаар / ковид-19-ийн гэрийн эргэлтийн багийг дэмжих, хавьтлаас шинжилгээ авах, вакцинжуулалт хийх, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зэрэг арга хэмжээнүүдийн нийт **93,846.2** мянган төгрөгийн зарлагын гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан,
- ИТХ нь 2021 оны үйл ажиллагааны тайлан мэдээлэл бүхий 1000 ширхэг сэтгүүл, гарын авлага, тогтоол шийдвэрийн эмхэтгэл хийлгэхэд 3,050.0 мянган төгрөг, сумын хамтарсан багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж зөвлөн туслах үйлчилгээнд 1,800.0 мянган төгрөг, жолоочийн тооцооны хуудсыг холбогдох маягт, аргачлалаар хөтлөөгүй, шатахууны норм, нормативыг зөрүүтэй тооцсон 6,046.2 мянган төгрөг зэрэг нийт **10,896.2** мянган төгрөгийн зарлагын ажил гүйлгээг гүйцэтгэж, шууд зардлаар тайлагнасан.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд үнэн зөв тусгаж байх албан шаардлага хүргүүлэх.

- **4.2.4** Холбогдох мэргэжлийн байгууллагын акт, дүгнэлт, ТӨБЗГ, аймгийн ОНӨГ-ын шийдвэр болон бусад шаардлагатай баримт материалын үндэслэлгүйгээр 10,451.3 мянган төгрөгийн өртөг бүхий чулуун склад, 28,420.0 мянган төгрөгийн авто машин / *тоёота марк-2, прадо-95, ачааны самосмал* / зэрэг нийт **38,871.3** мянган төгрөгийн үл хөдлөх хөрөнгө болон тээврийн хэрэгслийг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 40 дүгээр тогтоолоор данс бүртгэлээс хасах шийдвэр гаргаж, хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2009 оны 30 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Сумын төсвийн байгууллагын үндсэн хөрөнгө, тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжөөс бусад эд хөрөнгийг эзэмших, ашиглах актлах журам”-ын 2 дахь “Сумын төсвийн байгууллага нь үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл, машин механизм, үйлдвэрийн зориулалтай тоног төхөөрөмж, тэдгээрийн дагалдах хэрэгслээс бусад эд хөрөнгийг актлах тухай саналаа сумын Засаг даргад албан бичгээр тавина.” гэсэн заалт болон ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2 дугаар зүйлийг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Данснаас хассан хөрөнгийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан буцаан орлого авах, дээрх хөрөнгийг актлах саналыг аймгийн ИТХ, ОНӨГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэх албан шаардлага хүргүүлэх.

#### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Анхан шатны болон худалдан авалтын цахим баримттай холбоотой.**

Илрүүлэлт: Бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй болон Өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр, дүгнэлтгүйгээр автомашины засвар үйлчилгээнд нийт **99,982.8** мянган төгрөгийг зарцуулж, бүртгэл тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Тайлант онд ИТХ 7,499.7 мянган төгрөг, ЗДТГ 43,716.5 мянган төгрөг, Эмнэх өрхийн ЭМТ 16,564.1 мянган төгрөг, Номтхан өрхийн ЭМТ 10,536.0 мянган төгрөг, Бэлчир бүсийн ойн анги 10,000.0 мянган төгрөг, нийт **88,316.3** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.
  - Өмч хамгаалах зөвлөлөөр эдэлгээний хугацаа, зайлшгүй хийх шаардлагатай эсэх талаарх асуудлыг хэлэлцүүлж, дүгнүүлэлгүйгээр автомашины засвар үйлчилгээнд ЗДТГ 9,322.0 мянган төгрөг, ИТХ 2,344.5 мянган төгрөг нийт **11,666.5** мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийн зардал гаргасан байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

##### **2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: 2021 онд шинээр орлогод авсан **40,811.8** мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын жилийг тооцоогүй /ЗДТГ нь 26,811.8 мянган төгрөг, Эмнэх өрхийн ЭМТ нь 14,000.0 мянган төгрөг/ байгаа нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан "Сэлэнгэ аймгийн төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийн 5.4 дэх "Үндсэн хөрөнгийн бүртгэлийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа" гэж заасныг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Зөвлөмж: Дээрх хөрөнгүүдийн элэгдэл тооцох хугацааг 2022 оны эхний хагас жилд багтаан тооцох.

### **3.Нэмэгдэл цалин хөлстэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: 8-р цэцэрлэг нь төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3-д "Төрийн үйлчилгээний байгууллагын... албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу ... тооцож, сар бүр олгоно", Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35/А/10/9 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт"-ийн 6-д "Багш ажилтны ур чадварыг хагас жил тутамд үнэлж, нэмэгдлийг сар бүр олгоно" гэж заасныг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу дүгнэсний үндсэн дээр ур чадварын нэмэгдэл олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Залруулга				Төлбөрийн акт		Үүнээс		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
		/Мянган төгрөгөөр/													
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал															
1	ЗДТГ нь байгууллагын жижиг мөнгөн кассын арилжааны банкны үлдэгдлийг тайлагнаагүй орхигдуулсан	1	290.0	1	290.0										
2	Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад хөрөнгийн болон урсгал зардлыг нэмэгдүүлж төсвийн тодотгол хийсэн	1	31,152.7							1	31,152.7				
2	Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс дараах байгууллага, хөтөлбөрүүдэд авлага, өр төлбөр үүсгэсэн болон батлагдсан төсөв хэтрүүлсэн, нягтлан бодох бүртгэлийн бичилтийг буруу гүйцэтгэсэн.	1	36,317.8							1	36,317.8				
3	Үндэслэлгүйгээр хөрөнгө актлах шийдвэр гаргасан	1	38,871.3							1	38,871.3				
4	Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж бүртгэл, тайланд тусгасан	1	104,742.4							1	104,742.4				
5	БМ-ын худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй	1	99,982.8											1	99,982.8
6	2021 онд шинээр орлогод авсан хөрөнгийн ашиглалтын жилийг оруулаагүй	1	40,811.8											1	40,811.8
7	8-р цэцэрлэг нь төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдэл олгосон.	1												1	
	<b>Дүн</b>	<b>8</b>	<b>352,168.8</b>	<b>1</b>	<b>290.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>211,084.2</b>	<b>3</b>	<b>140,794.6</b>		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал															
1	ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1, 1.4 дэх заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.	1												1	
2	ТТЗ болон ИТХ, ЗДТГ нь шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон болон мэдээлээгүй байна.	2												2	
	<b>Дүн</b>	<b>10</b>	<b>352,168.8</b>	<b>1</b>	<b>290.00</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>6</b>	<b>211,084.2</b>	<b>3</b>	<b>140,794.6</b>		